

ДИЖИТАЛ ЭРИН ДАХЬ СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙ

Н.Ариунзаяа* Sorgoog**

* МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

** МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үгс: Дижитал манипуляци, AI, commission, omission, эрхийн тэнцвэржүүлэлт.

Энэ өгүүллийг бичихийн өмнө нэгэн домог санаанд орж ирэв. Эртний Грекийн домогт Дионез өөрийн албат Демокласд эд баялаг, эрх мэдлийн хор хөнөөлийг ойлгуулахын тулд нэгэн тансаг үдэшлэг зохион байгуулсан гэдэг. Үдэшлэгийн турш албат Демокласын толгой дээр ганц ширхэг үсээр дүүжилсэн хурц сэлэм өлгөөтэй байжээ. Хаан үүгээрээ нэг талаар эрх мэдэл, эд баялгийн таашаал, нөгөө талаар айдас түгшүүрийг мэдрүүлэхийг зорьсон байна. Эртний Грекийн энэ домогт өгүүлсэн дүр зургийг өнөөгийн сэтгүүл зүйгээс харж болох мэт санагддаг. Дижитал эрин нь тэрхүү домогт өгүүлдэг шиг тансаг сайхан үдэшлэгийг сэтгүүл зүйд бий болгож байна. Үүний хамгийн наад захын жишээ бол дижитал хэрэгслүүд юм. Мэдээллийн энэхүү шинэ эрин нь боломж олгохын зэрэгцээ бас мөнөөх домогт өгүүлдэг ганц үсээр дүүжилсэн толгой дээрх сэлмийг санагдуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл дижитал медиа, сэтгүүл зүйн ёс зүй хоёрын мөн чанар нь арга билэг хоёр шиг

эвцэлддэггүй байна. Үүнийг бид алхам тутамдаа харж болно.

Онолчид ёс зүйг зөв зүйл, эсвэл ёс суртахууны зан үйлийн зарчмаар тодорхойлдог. Гэтэл сэтгүүл зүйн ёс зүйн зарчмууд нь бүх нөхцөл байдалд тогтвортой үйлчлэх үү, эсвэл тухайн нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөрөөр үйлчлэх үү? гэсэн асуулт гардаг. Сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ёс зүйг ихэвчлэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг хариуцлагатай ажиллахад нь туслах зорилгоор тодорхойлдог. Тэрхүү ёс зүйн нийтлэг зарчим нь:

- Нарийвчлалтай байх,
- Бие даасан байх,
- Алагчлалгүй байх,
- Хүнлэг байх,
- Хариуцлагатай (accountablejournalism.org) байх гэсэн ойлголтуудаас бүрддэг.

Эдгээр зарчмууд сэтгүүл зүйн үйл ажиллагаанд зааварчилгаа болдог хэдий ч сэтгүүл зүйн дүр төрх, мөн чанар, үнэ цэнэ, хамрах хүрээ, оролцох оролцогчид нь өдрөөс өдөрт өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа өнөөгийн нөхцөл байдал нь дээр дурдсан зарчмуудыг хүчинтэй байх боломжгүй болгож байгаа юм.

Жишээлбэл, гурван хэмжээст технологи сэтгүүл зүйн үйл ажиллагаанд нэвтэрч, мэдээлэл түгээх нэг хэлбэр болох хандлага аль хэдийн бий болсон (Ricardo Cruz R. N., 2011). Энэ технологи нь үзэгдэл, үйл явдлыг бодит мэт болгон үзүүлж, сонсгож, мэдрүүлэх арга юм. Бусад шинжлэх ухаан тэр дундаа анагаахын салбарт аль хэдийн хэрэглээд эхэлсэн (Nawrat A., 2018) энэ технологийг сэтгүүл зүйд хэрхэн ашиглах вэ, ёс зүйн хэм хэмжээг хэрхэн хадгалах вэ? гэсэн асуулт зүй ёсоор гарч ирж байна. Тухайлбал, гурван хэмжээст мэдээллийн үнэн зөв эсэхийг хэрхэн баталгаажуулах вэ, энэ технологи сэтгүүл зүйн ямар үйл ажиллагаанд тохиромжтой, ямарт нь тохиромжгүй вэ? гэх мэт олон асуудал тулгарч байна. Гэтэл манай болон дэлхий дахины мэргэжлийн сэтгүүлчдийн байгууллагын ёс зүйн кодоод энэ талаар тусгасан заалт үгүй байна.

Технологийн хувьсал өөрчлөлтийн цаашдын хөгжлийг таамаглах боломжгүй юм. Энэхүү тааж болшгүй хөгжил, шинэчлэл нь нийгмийн эмзэг мэдрэмтгий салбар болох сэтгүүл зүйд ихээхэн өөрчлөлтийг оруулж байна. Тэгэхээр шинэ нөхцөл байдал, уур амьсгалд хэрхэн зохицож, ёс зүйн хэм хэмжээгээ баримталж ажиллах нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын тулгамдсан асуудлын нэг болж байна.

Сэтгүүлчийн ёс зүйн хүрээнд хамаарах ёс бус үйлдлийг хоёр янзаар авч үзвэл зүйтэй болно. Үүний нэг нь commission буюу сэтгүүлчийн ёс зүйд харш аливаа үйлдлийг хийх, нөгөөх нь omission (Reamer F. G., 2015) буюу чухал мэдээллийг зориуд орхигдуулах, эс үйлдэх явдал болно. Дээрх хоёр зөрчлийн эхнийх нь үзэгдэл, үйл явдлыг мэдээлж байх явцдаа гаргасан ёс зүйн алдаа, нөгөөх нь мэдээлэл хийхгүй

буюу бусармаг үйлдлийн хажуугаар дуугүй өнгөрөх, заавал мэдээлэх, ил болгох ёстой зүйлийг санаатайгаар орхигдуулах зөрчил юм. Ийм зөрчлийн олонх нь хувийн эрх ашгаа бодсонтой холбоотой байдаг. Жишээлбэл, эх сурвалжтай ярилцаж байхдаа асуух ёстой асуултыг санаатайгаар орхигдуулах нь энэ төрлийн зөрчилд хамаарна.

Ерөөс дижитал эриний сэтгүүл зүйн ёс зүйн алдаанд дараах зүйлүүдийг хамааруулж болно.

Үүнд:

Manifulation. Өнөө үед дижитал манипуляци буюу зураг болон видео бичлэгийг өөрчлөх нь ёс зүйн ноцтой алдаа болж байна. Ийм үйлдлийн анхны оролдлого нь 1982 онд “Нэйшнл Жиогаф”-ийн редактор сэтгүүлийнхээ нүүрэнд тохиромжтой байхыг нь бодож Египетийн пирамидын байршлыг өөрчилж (Nickle R., 2017) тавьсан байдаг. Судлаачид үүнийг сэтгүүл зүйн салбарын анхны дижитал манипуляци гэж үздэг. Тэр явдлаас хойш өнгө солихоос эхлээд уулзаагүй хүмүүсийг уулзуулах, хийгээгүй зүйлийг хийлгэх нь наад захын хэрэг болсон. 2000 онд тухайн үеийн Америкийн ерөнхийлөгч Билл Клинтон, Кубын ерөнхийлөгч Фидел Кастро нар уулзахдаа гар барьж мэндлээгүй (Sanger D. E., 2000). Гэтэл дараа нь тэднийг гар бариулсан зураг медиагаар тарсан. Монголд ч ийм зүйл түгээмэл болдог. Тухайлбал, ерээд онд гарч байсан “Шүүдэр” хэмээх сонинд “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирал Ш.Отгонбилэг ажилтан н.Буяндэлгэр гэдэг залууд шагнал гардуулаад баяр хүргэн гар барьж буйг дүрсэлсэн зурагт ерөнхийлөгч Н.Багабандийн толгойг залгаж “Андын нөхөрлөл алдраагүй цагт атгасан гар алдуурахгүй” гэсэн тайлбар хийсэн нь “Ш.Отгонбилэг Эрдэнэтийн хөрөнгөөр Н.Багабанди,

Ц.Балдорж хоёрыг баяжуулсан” хэмээн олны дунд тархсан яриаг баталгаажуулах зорилго агуулсан байжээ. Өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, контент үйлдвэрлэгчдийн хувьд энэхүү манипуляци “газар авч” улсын ерөнхийлөгч, ерөнхий сайдаас авхуулаад олны танил эрхмүүд болон энгийн ард гэх мэт хэнийг ч автуулдаг болжээ.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдийн хэрэгслийн имиж, өнгө төрх, орон зайд тааруулан контентыг засварлах, тайрах, нэмэх шаардлага гардаг бөгөөд эдгээр нь ёс зүйн үүднээс асуудал дагуулж байдаг. Ийм үйлдэл контент нэмж хамах, олон зураг нэгтгэж эвлүүлэг хийх, зураг зохиох, аудио, видео дүрс бүтээх буюу болоогүй зүйлийг болсон мэт болгох хэлбэрээр илэрдэг. Эдгээрийг арилжааны болон техникийн дэвшлийн үүднээс харвал гайхамшиг мэт боловч сэтгүүл зүйн тэр дундаа ёс зүйн цонхоор харахад тийм ч таатай хэрэг биш юм. Дээр дурдсанчлан дижитал медиа, сэтгүүл зүй хоёрын ёс зүй нь бие биедээ таарамжтай биш зүйлүүд юм. Энэ нь тухайн агуулгын утгыг өөрчилж, гажуудуулж байгаад л хамаг буруу нь оршиж байна. Ерөөс зураг, видео, аудио хэзээ ч засварлаж, өөрчилж болохгүй.

Дижитал хэлбэрээр өөрчилсөн дуу, дүрс, хиймэл зураг, анимейшн, 3D зургийг тодорхой шошготой болгох хэрэгтэй бөгөөд ингэснээр үзэгч, сонсогчид тухайн контент бодит, эсвэл агуулга ба хэлбэр дүрсийг өөрчилсөн ал нь болохыг мэдэх бололцоотой юм.

Энэхүү тэмдэглэгээ нь сэтгүүл зүйн үнэ цэнийг эрхэмлэх, шударга ажиллах цорын ганц арга зам. Өөр нэг асуудал бол дижитал технологийг ашигласнаар мэдээ цуглуулах явцад ёс зүйн шинэ асуудалтай тулгарч эхэлсэн явдал юм. Жишээлбэл, 360 градусын өргөн өнцгөөр хардаг камер нь сэтгүүлчийн харах талбайг өргөсгөдөг. Тийм хэрэгслүүд мэдээг илүү тодорхой болгодог ч ёс суртахууны хувьд тийм ч таатай хэрэг биш юм. Эсэргүүцэл, улс төрийг жагсаал цуглааны зургаар жишээлж үзье. Уламжлалт нарийн өнцөгттэй дуран бүхий камер зөвхөн жагсагчдыг л харуулдаг бол а bird’s-eye angle буюу

бүх чиглэлд хардаг камераар жагсагчдаас гадна дэргэд байгаа хүмүүс болоод орчин тойрны бүх юмсыг харж болно. Зохицуулж байгаа цагдаагийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажиглагчид ч дуранд өртөнө. Ингэснээр үйл явдлыг илүү өргөн хүрээнд бүрэн дүүрэн тусгах бололцоотой хэдий ч

хэн нэгний эрх ашгийг зөрчих, хувийн орон зайд халдах, хэлмэгдүүлэх зэрэг ёс зүйн ноцтой асуудлыг дагуулах магадлалтай юм. Мөн өндөр пикселтэй дижитал камераар алсад байгаа объект болон хүмүүсийг татаж авах үед дээрх зөрчил гарах эрсдэл өндөр болдгийг санах хэрэгтэй.

Нууц камер. Ёс зүйтэй сэтгүүлчийн чухал чадварын нэг нь эрхийн тэнцвэржүүлэлт юм. Нэг талд олон нийт мэдэх эрхтэй байхад нөгөө талд иргэд хувийн нууцтай байдаг. Үүнийг тэнцвэртэй хадгалах ёстой юм. Нууц камераар



Дижитал хэлбэрээр өөрчилсөн дуу, дүрс, хиймэл зураг, анимейшн, 3D зургийг тодорхой шошготой болгох хэрэгтэй бөгөөд ингэснээр үзэгч, сонсогчид тухайн контент бодит, эсвэл агуулга ба хэлбэр дүрсийг өөрчилсөн ал нь болохыг мэдэх бололцоотой юм



сансраас хүртэл зураг авч, түүнийг алган дээр байгаа юм шиг тодорхой харж болно. Энэ бол дижитал эриний гайхамшиг. Мэдээжийн хэрэг байгалийн элдэв гамшигт үзэгдэл, цунами, газар хөдөлсний ул мөр, мөстлөг хайлах зэргийн зураг авах нь зүй ёсны хэрэг. Гэтэл хүсэхгүй байхад нь хүний хувийн нууцад халдах нь ёс зүйгүй хэрэг юм. Манай хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа телевиз, цахим мэдээллийн сайтууд авто машины осол орж, алуурчны гарт өртөж амиа алдсан хүний цус нөждөө будагдсан цогцсыг эрээ цээргүй үзүүлдэг нь нэгд нийгмийн сэтгэл зүйд таагүй уур амьсгал төрүүлж, хоёрдугаарт хүний эрхийг зөрчсөн ноцтой алдаа юм.

Төрийн нууцыг ил болгох. Дижитал ил тод байдал нь үндэсний аюулгүй байдалтай холбогдох үед ёс зүйн асуудал хурцаар тавигдаж эхэлдэг. Энэ үед нэг талаар ёс зүйн хэм хэмжээнээс хальсан зөрчил, нөгөө талаар үндэсний эрх ашгийг хамгаалах шаардлага гэсэн хоёр асуудал тулгардаг. 2006 онд “Нью-Йорк Таймс” зэрэг сонинууд утас болон дижитал холбооны янз бүрийн технологийг ашиглан эсрэг талынхнаа тагнаж байсныг илчилснээр асуудал олон нийтийн өмнө ил болсон. 2010 онд Жулиан Ассанжийн “Wikileaks” сайт засгийн газар болон цэргийн олон мянган нууц баримтыг дижитал хэлбэрээр илчилсэн. Үүний дараа уг үйлдэл зөв байсан уу, эсвэл гэмт хэрэг үү, сэтгүүл зүйн байгууллагууд “Wikileaks”-ийн асар олон баримтыг ашиглан олон өгүүлэл материал нийтэлсэн нь ёс зүйн хувьд зөв байсан уу? гэх мэт олон асуулт ундарсан. Эх сурвалжид нэвтэрч, үзэгдэл, үйл явдлын мөрөөр орох нь мэдээллийн үйл ажиллагааны чухал элементүүдийн нэг юм. Үүнийг гагцхүү ёс суртахууны болон хуулийн хил

хязгаарыг зөрчихгүйгээр хийнэ гэдэг нь сэтгүүлчийн өмнө тулгардаг ёс зүйн том сорилт болдог. Үүний нэг жишээ Их Британийн “News of the World” сэтгүүлийн утасны хакерын дуулиан байлаа. Сэтгүүлч болон тэдний итгэмжлэгдсэн хүмүүс гар утсыг хакердаж сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээ төдийгүй Их Британийн хуулийг ноцтой зөрчсөн юм. Мэдээжийн хэрэг гар утас, имэйл, социал медиа гэх мэт дижитал харилцаа холбооны технологи, түүнчлэн нээлттэй мэдээллийн баазууд, дижитал мэдээллийн асар их цуглуулга нь сэтгүүлчийн анхаарал татах эх сурвалж мөн. Гэхдээ мэдээлэл олж авахаас эхлээд түгээх хүртэлх үйл ажиллагаа гагцхүү ёс зүйн хэм хэмжээнд явагдах учиртай. Ингэхийн тулд өөртөө дараах асуултыг тавь. Энэ мэдээллийг олж авах өөр эх сурвалж байсан уу, хувь хүн болон хүүхдийн хувийн нууц хөндөгдөх үү, ингэж асуусны дараа ёс зүйн хэм хэмжээгээ зөрчин байж, өөрийгөө үгүйсгэн байж олж авсан мэдээлэл маань олон нийтэд ач холбогдолтой, тустай байж чадах эсэхийг тунгаан бодоорой.

Алан Тюринг. Дижитал медиагийн ёс зүйн тухай ярих үед хөндөхгүй өнгөрч болохгүй нэг зүйл бол AI (Cowell A. , 2019) буюу хиймэл оюун ухаан юм. Энэ нь өнгөрсөн зууны тавиад оноос эхэлсэн үйл ажиллагаа бөгөөд өнөөдөр зөвхөн датад тулгуурлан мэдээ бэлтгэх хэмжээнд хүртэл хөгжиж байна. Энэ аргыг эдийн засаг, спортын сэдэвт мэдээлэлд түлхүү хэрэглэх болсон юм.

Гэхдээ компьютероор бичсэн мэдээллийн ёс зүй гэж юу вэ, ерөөсөө түүнд ёс зүйн асуулт тавьж болох уу, хүний гараар бичээгүй мэдээллийн шударга ёс, нарийвчлал, хариуцлагыг хэн хүлээх вэ гэх мэт асуултуудын нөгөө талд ерөөсөө компьютероос өөр объек-

тив зүйл байх боломжтой юу? гэх мэт олон асуулт гарч ирнэ. Энэ бүхэнд өнөөдрийг хүртэл тулхтай хариулт нэхэгдсээр байна.

Нэрээ нууцалсан эх сурвалж. Дэлхийн сэтгүүл зүйн түүхэнд нэрээ нууцалсан эх сурвалжийн мэдээллийн мөрөөр хийсэн хамгийн том үйл ажиллагаа бол АНУ-ын ерөнхийлөгч Ричард Никсоныг огцруулсан “Вашингтон пост”-ын сэтгүүлч Бов Вудвард, Карл Вернстайн нарын сурвалжилга юм. Тэд уг нийтлэлээрээ Пулицерийн шагнал хүртсэн юм. Гэтэл нэрээ нууцалсан эх сурвалж бүгдээрээ ёс зүйтэй, нарийвчлалтай байж чаддаггүй. Өнөө үед нэрээ нууцалсан эх сурвалжийн мэдээлэл олонх тохиолдолд сенсац, хэт нэг талыг барьсан шинжтэй байх болсон. Хоёр дахь тохиолдолд сэтгүүлч үзэгдэл, үйл явдлын нөгөө талын байр суурийг харгалзахгүйгээр мэдээлэх явдал түгээмэл байна.

Гэмт хэрэг, аюул заналхийлэл гэх мэтийн эрэн сурвалжлахаас бусад тохиолдолд нэрээ нууцалсан эх сурвалжийн мэдээлэлд туйлын няхуур нямбай хандах нь зүйтэй. Тодруулбал, үүний цаана юу байна, нууцлах ямар шалтгаан байв гэдгийг магадлах нь чухал юм.

Үг хэлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд дулдуйдан, сэтгүүлчийн ёс зүйг зөрчих явдлын цадигаа алдсан жишээнүүд ерээд онд олон гарсан. Нэр, төр, ашиг хонжоо олох гэсэн бэртэгчин этгээдүүдийн тараасан элдэв цуу үгийг уухайлан түрэхэд тухайн үеийн үндэсний телевиз ч хувь нэмрээ оруулж байсныг санахад илүүдэхгүй. Гал гаргадаг Б.Өнөрмаа, далдыг хардаг Ч.Дашцэрэн, харь гаригийн гийчидтэй уулздаг П.Мөнхцэцэг, алтан цөгцний өрөнд орсон н.Төмөрбаатар гээд нийгмийг бүхэлд нь доргиосон худал хуурмаг

зүйлийг МҮОНТ хөөрөгдөн дэвэргэж байв. Д.Дожоодорж, Ш.Гүрбазар, Б.Жаргалсайхан, О.Дашбалбар зэрэг манай хашир туршлагатай уран бүтээлчид хүртэл хоосон чулуу хөөж, үзэгчдээ хуурч байлаа. Энэ мэт нийтлэл нэвтрүүлгийг үзэж сонссон олон нийт даган дуурайх сэтгэлгээндээ хөтлөгдөн, гайхширан төөрөлдөж байсан нь нууц биш юм.

Нууц нэр ашиглах. Ийм тохиолдол олон байдаг. Үүнийг зарим тохиолдолд “уран бүтээлийн нэр” гэдэг үгээр тайлбарлах нь бий. Гэтэл нууц нэр хэрэглэсэн эх сурвалжийн олонх нь хэрэглэгчдийг хуурч, сэтгүүлчийн ёс зүйг зөрчсөн байдаг. Энэ нь эцсийн дүндээ олон нийтийн итгэл алдрах, сэтгүүлчид хийгээд олон нийтийн харилцаанд сэв суух хэвлэл мэдээллийн хэрэгсэл болоод сэтгүүлчдийн нэр хүнд унаж, мэдээлэлд итгэх итгэл үгүй болох зэрэг сөрөг үр дагаварт хүргэдэг.

Мэдээлэх үйл явцад гардаг алдаанаас гадна эс үйлдэх ёс зүйн алдаа цөөнгүй. Дижитал эринд гардаг эс үйлдэх ёс зүйн алдааны олонх нь мэдээлэл цуглуулах явцад гардаг. Уламжлалт сэтгүүл зүйн үед сэтгүүлчид мэдээлэл цуглуулахдаа эх сурвалжтай биечлэн уулздаг байсан бол өнөөдөр төхөөрөмж ашиглаж, бүр багадаа гар утсаар мэдээлэл олж авдаг болсон. Энэ нь хэдийгээр хөдөлмөр хөнгөвчилж, цаг хэмнэж байгаа боловч олон зүйлийг орхигдуулах шалтгаан болдог.

Тухайлбал, биечлэн уулзаж байгаа нөхцөлд сэтгэл хөдлөлийн байдал, хариу үйлдэл, нүүр царайны хувирал зэргийг ашиглах замаар асуух асуултаа сонгох, өөрчлөх боломжтой байдаг. Ганцаарчилсан уулзалтаар мэдээлэл олж авах нь нарийн ширийн зүйлийг олж мэдэх өргөн боломжийг нээж өгнө.

Гар утас, телефон утас, интернэт, и-мэйл ашигласнаар алсаас ярилцах нь хурдан бөгөөд хялбар, хямд болсон хэдий ч баримт мэдээллийг шалгах үйл явц орхигдох болсон. Зардал хэмнэх, шуурхай мэдээлэх гэж яарах нь дижитал мэдээллийн алдааны гол шалтгаан болж байна. Онлайн, шууд мэдээлэлд гарсан алдааг засах боломж хомс учраас ямар алдаа гарсан тухай мэдээлж хэрхэн залруулснаа хүлээн авагчдад тайлагнах нь зөв юм. Уламжлалт мэдээллийн хэрэгслүүд гарсан алдаандаа “залруулга” хийж хэвшсэн байдаг бөгөөд ингэснээр мэдээллийн ажилтнуудыг хариуцлагатай болгож, хүлээн авагчдын итгэлийг нэмэгдүүлдэг байв. Блог, жиргээ гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд энэ загварыг мөрдөж хэвших нь чухал юм. Мэдээллийн хэрэгслийн хэлбэрээс үл хамааран хэвлэн нийтлэх, залруулах, бүртгэл хөтлөх зэрэг нь ёс зүйн хэм хэмжээг сахиулах үйл хэргийн салшгүй хэсэг болно. Эцэст нь дижитал мэдээллийн хэрэгсэлд гарч байгаа ёс зүйн алдаа нь үйлдлийн болон эс үйлдлийн гэсэн хоёр хэлбэрээр илэрч байгааг дахин тэмдэглэж ардчилсан нийгмийн хөгжилд ёс зүйтэй хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа чухал түлхэц болдгийг сануулъя.

Эшлэл

1. Alan Cowell. (2019). Overlooked No More: Alan Turing, Condemned Code Breaker and Computer Visionary. New York Times.
2. Allie Nawrat. (2018). 3D printing in the medical field: four major applications revolutionizing the industry.
3. David E. Sanger. (2000). SUMMIT IN NEW YORK: A CUBAN MOMENT; It's a Handshake and Small Talk for Clinton and Castro. New York Times.
4. Frederic G. Reamer. (2015). Eye on Ethics: Omission and Commission in Social Work Ethics.

5. Raigan Nickle. (2017). Visual Deceptions: National Geographic and the Pyramids of Giza.
6. Ricardo Cruz, Ricardo N. Fernandes. (2011). Journalism of Virtual Worlds Research.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. (2007). Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
2. Ариунзаяа Н., Мэндхүү Г., Өнөрсайхан Т., Бат-оюун Б., (2022). Impact of Digital Information and Communication Technology on Oral Tradition of Mongolian Nomadic Lifestyle. Ирланд.
3. Alan Cowell. (2019). Overlooked No More: Alan Turing, Condemned Code Breaker and Computer Visionary. New York Times.
4. Allie Nawrat. (2018). 3D printing in the medical field: four major applications revolutionizing the industry.
5. David E. Sanger. (2000). SUMMIT IN NEW YORK: A CUBAN MOMENT; It's a Handshake and Small Talk for Clinton and Castro. New York Times.
6. Frederic G. Reamer. (2015). Eye on Ethics: Omission and Commission in Social Work Ethics.
7. Raigan Nickle. (2017). Visual Deceptions: National Geographic and the Pyramids of Giza.
8. Ricardo Cruz, Ricardo N. Fernandes. (2011). Journalism of Virtual Worlds Research.
9. www.accountablejournalism.org

Summary

This article discusses the changes in journalistic ethics in the digital age. It highlights issues that were not discussed in the ethical framework of journalism before digital technology's influence affected journalism so much. Which has now become a pressing issue of journalistic ethics today.